



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |     |
|------|--|-----|
| 210. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай           | 898 |
| 211. | Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай | 898 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 212. | Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 35 | 899 |
|------|--|-----------|-----|

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 213. | Зарим хүмүүсийг анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 53 | 899 |
| 214. | Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай   | Дугаар 54 | 905 |
| 215. | Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай  | Дугаар 55 | 905 |
| 216. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай   | Дугаар 56 | 906 |
| 217. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай   | Дугаар 60 | 906 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |            |     |
|------|---|------------|-----|
| 218. | Бэлэн байдлын зэрэг, хорио цээрийн дэглэмийг цуцлах тухай | Дугаар 110 | 907 |
|------|---|------------|-----|

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 219. | Арбитрын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 04 | 908 |
|------|---|-----------|-----|



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Амгалан дулааны станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмжийг импортлоход гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тоног төхөөрөмжийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Амгалан дулааны станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмжийг импортлоход нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тоног төхөөрөмжийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 05 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар  
хот

### **Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлийн 39<sup>1.2</sup> дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Халтмаагийн Баттулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 05 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

### **Зарим хүмүүсийг анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.4, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Энэхүү зарлигийн хавсралтад дурдсан хүмүүсийг анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны  
5 дугаар сарын 09-ний өдрийн 53 дугаар  
зарлигийн хавсралт

**Нэг.Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:**

1. Гомбын Лхагвамааг Иргэний хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
2. Оросоогийн Нарангэрэлийг Иргэний хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
3. Ёндонгийн Бямбацэрэнг Иргэний хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.

**Хоёр.Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:**

1. Арвинбуянгийн Энхбаатарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
2. Данзангийн Эрдэнэбилэгийг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 4 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
3. Жигдэнгийн Баттогтохыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
4. Дагвын Жамбалсүрэнг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
5. Пүрэвсүрэнгийн Батсайханг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
6. Зундуйн Хосбаярыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 8 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
7. Батжаргалын Батзоригийг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.



**Гурав.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:**

1. Бавалын Баатарыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
2. Пунцагийн Цэцэгдуламыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
3. Батдоржийн Нармандахыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.

**Дөрөв.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:**

1. Мөнхбаярын Алдарыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
2. Ёндонгийн Цогтзанданг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
3. Дамдинсүрэнгийн Оюунбатыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
4. Нямдоржийн Одонтуулыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд.

**Тав.Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:**

1. Баттулгын Одонтуяаг Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
2. Зукарын Гульбаршаг Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
3. Сангибатын Сайнбилэгийг Захиргааны хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
4. Шаравын Баттогтохыг Захиргааны хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд;



5. Далантайн Нарантуяаг Захиргааны хэргийн анхан шатны 6 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

6. Батбаярын Оюуныг Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

7. Лхагважаргалын Тунгалагийг Захиргааны хэргийн анхан шатны 10 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

8. Баттуулайн Болормааг Захиргааны хэргийн анхан шатны 11 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

9. Сангаагийн Отгонцэцэгийг Захиргааны хэргийн анхан шатны 12 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

10. Цэдэн-Ишийн Нэргүйг Захиргааны хэргийн анхан шатны 13 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

11. Хаянхярваагийн Эрдэнэтуяаг Захиргааны хэргийн анхан шатны 14 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

12. Бат-Өлзийн Хажидмааг Захиргааны хэргийн анхан шатны 15 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

13. Түмэнжаргалын Оюунгэрэлийг Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

14. Гомбосүрэнгийн Сонинболорыг Захиргааны хэргийн анхан шатны 17 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

15. Балжирхүүгийн Энхтайванг Захиргааны хэргийн анхан шатны 18 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

16. Намсрайн Балжмааг Захиргааны хэргийн анхан шатны 19 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

17. Цэрэннадмидын Батсүрэнг Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.



**Зургаа.Сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд:**

1. Ванд-Очирын Цэцэнбилэгийг Сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
2. Дашдоржийн Мөнхөөг Сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
3. Батаагийн Гэрэлмааг Сум дундын 3 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
4. Содовын Цэрэндуламыг Сум дундын 4 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
5. Цанжаагийн Үйтүмэнг Сум дундын 5 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
6. Одцэрэнгийн Однямааг Сум дундын 6 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
7. Банзайн Манлайбаатарыг Сум дундын 7 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
8. Хасбаатарын Ганболдыг Сум дундын 8 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
9. Эрдэнэ-Очирын Болормааг Сум дундын 9 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
10. Сүхбаатарын Ганчимэгийг Сум дундын 10 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
11. Сүхбаатарын Сэржмядагийг Сум дундын 11 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
12. Доржийн Нямыг Сум дундын 12 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;
13. Чадраагийн Энхтөрийг Сум дундын 13 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;



14. Бат-Очирын Бямбасүрэнг Сум дундын 14 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

15. Равданжамцын Уранчимэгийг Сум дундын 15 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

16. Цэрэнчимэдийн Мөнхтулгыг Сум дундын 16 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

17. Хумбаагийн Отгонжаргалыг Сум дундын 17 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

18. Хаянхярваагийн Оюунжаргалыг Сум дундын 18 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

19. Пунцагжавын Болормааг Сум дундын 19 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

20. Лхагвын Энхтайванг Сум дундын 20 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

21. Бямбаагийн Алтанцэцэгийг Сум дундын 21 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

22. Цэдэвийн Отгонжаргалыг Сум дундын 23 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

23. Лхамсүрэнгийн Алтанг Сум дундын 24 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

24. Тумагийн Цэцэгмааг Сум дундын 25 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

25. Баттулгын Бадрахгэрэлийг Сум дундын 26 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

26. Түмэндэмбэрэлийн Хүрэлбаатарыг Сум дундын 27 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд;

27. Төмөрбаатарын Болормааг Сум дундын 29 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд.





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 05 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

### **Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дашцоодолын Дэлгэрцэцэг, Энэбишийн Солзаяа, Дашнямын Цогтсайхан, Шаравын Оюунханд нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгчийн, Халзанхүүгийн Гэрэлмааг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 3 дугаар шүүхийн шүүгчийн, Довдонгийн Очмандах, Сосорбурамын Соёмбо-Эрдэнэ нарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгчийн, Энхбатын Зоригтбаатар, Бямбаагийн Тунгалагсайхан, Энхтуяагийн Халиунбаяр, Ноостын Хонинхүү нарыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 05 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

### **Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Энэбишийн Солзаяаг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Дашцоодолын Дэлгэрцэцэг, Шаравын Оюунханд, Бямбаагийн Тунгалагсайхан нарыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгчийн, Дашнямын Цогтсайхан, Нямдоржийн Одонтуул,



Сосорбурамын Соёмбо-Эрдэнэ нарыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Довдонгийн Очмандахыг Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгчийн, Энхбатын Зоригтбаатар, Энхтуяагийн Халиунбаяр нарыг Захиргааны хэргийн анхан шатны 5 дугаар шүүхийн шүүгчийн, Намсрайн Балжмааг Захиргааны хэргийн анхан шатны 14 дүгээр шүүхийн шүүгчийн, Шаравын Баттогтохыг Сум дундын 5 дугаар шүүхийн шүүгчийн, Халзанхүүгийн Гэрэлмааг Сум дундын 15 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2014 оны 05 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Монакогийн Хант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шүхэрийн Алтангэрэлийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Монакогийн Хант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Мундагбаатарын Батсайханыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2014 оны 05 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар  
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,  
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр



зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бахрейны Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кадырийн Сайрааныг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бахрейны Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содномын Энхбатыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2014 оны 4 дүгээр  
сарын 4-ний өдөр

Дугаар 110

Улаанбаатар  
хот

### **Бэлэн байдлын зэрэг, хорио цээрийн дэглэмийг цуцлах тухай**

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорноговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний голомт устаж, халдварын тархалт зогссонтой холбогдуулан Сүхбаатар аймгийн Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр, Түвшинширээ, Хэнтий аймгийн Галшар, Дорноговь аймгийн Алтанширээ, Дэлгэрэх сумдын нутагт тогтоосон хорио цээрийн онцгой дэглэм, Сүхбаатар аймгийн Асгат, Халзан, Уулбаян, Мөнххаан, Хэнтий аймгийн Баянхутаг, Баянмөнх, Дэлгэрхаан, Дорноговь аймгийн Өргөн, Сайхандулаан сумдын нутагт тогтоосон хязгаарлалтын дэглэм болон тус аймгуудын төрийн захиргааны бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлснийг 2014 оны 4 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн тус тус цуцалсугай.

2. Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Их хэт сумдад тогтоосон хорио цээр, хязгаарлалтын дэглэм, шүлхий өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зохих зэрэгт шилжүүлэн ажиллахыг аймгийн Засаг дарга П.Ганхуягт даалгасугай.



3. Монголын нөхцөл байдал, онцлогийг харгалзан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аргыг оновчтой болгох талаар санал боловсруулан энэ оны 4 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулгад даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 39 дүгээр тогтоолын 1, 2, 3, 4 дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**Д.ТЭРБИШДАГВА**

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

2014 оны 05 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар  
хот

**Арбитрын тухай хуулийн зарим заалт  
Үндсэн хуулийн холбогдох заалтыг  
зөрчсөн эсэх тухай маргааныг хянан  
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 11.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа /илтгэгч/, Ш.Цогтоо, Д.Наранчимэг, Д.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Номынбаясгалан оролцов.



Хуралдаанаар Арбитрын тухай хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Байнгын арбитр энэ хуулийн 15.5-15.7, 17.4, 18.2, 20.6-д шүүх шийдвэрлэхээр заасан маргааныг өөр этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн этгээдийн гаргасан шийдвэр эцсийн байна.”, 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 15.5-15.7-д заасан маргаантай асуудлаар гаргасан давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.”, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 18.1-д заасан асуудлаар үүссэн маргааныг давж заалдах шатны шүүх болон байнгын арбитрын дүрэмд заасан эрх бүхий этгээд шийдвэрлэх ба тухайн шийдвэр эцсийн байна.”, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт “Талууд энэ хуулийн 20.5-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болох ба тухайн шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах, ... эрхтэй. ...”, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2/ дахь заалтад “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэж заасныг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

***Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хороонд оршин суугч, иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:***

“Улсын Их Хурлаас 2003 оны 5 дугаар сарын 9-ний өдөр баталсан Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Байнгын арбитр энэ хуулийн 15.5-15.7, 17.4, 18.2, 20.6-д шүүх шийдвэрлэхээр заасан маргааныг өөр этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн этгээдийн гаргасан шийдвэр эцсийн байна.”, 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 15.5-15.7-д заасан маргаантай асуудлаар гаргасан давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.”, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт “Талууд энэ хуулийн 20.5-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд



гомдол гаргаж болох ба тухайн шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэж хуульчилсан.

Дээрх заалтууд нь нэг талаас гэрээний талуудын хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой тодорхой төрлийн маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон маргааныг эцэслэн шийдвэрлэх эрх бүхий субъект, түүний эрх мэдлийг тодорхойлж, эрх олгосон диспозиц байхаас гадна нөгөө талаас маргаанд оролцогч субъектүүдэд Үндсэн хууль болон процессын хуулиар олгосон эрхээ хамгаалах боломжийг хязгаарлаж, дээд шатны шүүхэд /Улсын дээд шүүх/ хандах эрхийг хориглосон диспозиц байна. Үндсэн хуулиар Улсын дээд шүүхэд олгосон давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх бүрэн эрхэд нь халдсан гэж үзэж болохоор байна.

Арбитрын тухай хуулийн Үндсэн хууль зөрчсөн талаар дүгнэлт гаргуулахыг зорьж байгаа заалтын хувьд дараах тайлбарыг хийж байна.

Арбитрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 15.5-15.7-д заасан маргаантай асуудлаар гаргасан давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтад “... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчиж, иргэний эрхийн байдлыг алдагдуулж байна.

Арбитрч үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болох юм бол Арбитрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Арбитрч алив бодит шалтгааны улмаас үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болсон, эсхүл арбитрч байхаас өөрөө санаачилгаараа татгалзаж, талууд үүнийг нь зөвшөөрсөн бол уг арбитрчийн тухайн маргаанаар ажиллагаа явуулахтай холбоотой эрх, үүрэг дуусгавар болно.” гэж зохицуулсан боловч тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 18.1-д заасан асуудлаар үүссэн маргааныг давж заалдах шатны шүүх болон байнгын арбитрын дүрэмд заасан эрх бүхий этгээд шийдвэрлэх ба тухайн шийдвэр эцсийн байна.” хэмээн арбитрчийн үүргээ биелүүлээгүй талаарх маргааныг шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хяналтын журмаар гомдол гаргах боломжгүйгээр эцэслэгдэн шийдвэрлэгдэхээр хуульчилсан байна.

Маргааны харьяалал тогтоох эрхийн талаар Арбитрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Арбитрын бүрэлдэхүүн энэ

хуулийн 20.3, 20.4-т заасан гомдлын талаар урьдчилан шийдвэр гаргах, эсхүл энэ тухай үндсэн шийдвэртээ тусгана.” гэж заасан боловч тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт “Талууд энэ хуулийн 20.5-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болох ба тухайн шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэсэн нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах боломжгүйгээр маргаан эцэслэн шийдвэрлэгдэхэд хүргэж байна.

Иргэний эрхийн хамгаалалтын механизмыг бүрдүүлэх үндсийг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, ... зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах, ... эрхтэй. ...” гэж хуульчилж өгсөн. Энэхүү эрхүүд хэрэгжих эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх нь төрийн үүрэг гэдгийг Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” хэмээн баталгаажуулсан. Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2/ дахь заалтад “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;” гэсэн бүрэн эрхийг Улсын дээд шүүхэд олгосноор “эрх зүйт төр”-ийн механизмыг бүрдүүлж, Үндсэн хууль дахь “хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчмыг бодитоор нь хамгаалах баталгааг бүрдүүлж өгсөн байна. Гэвч талуудаас арбитрын зарим маргаанаар, тухайлбал, арбитражийг томилох, маргааны харьяалал тогтоох гэх мэт асуудлаар давж заалдах шатны шүүхээс гаргасан шийдвэрт талууд /иргэн/ хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хязгаарлаж хуульчилсан нь Үндсэн хуульд заасан шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг хязгаарласан байна.

Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гээд тус хэсгийн 2/ дахь заалтад “ давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэж зохицуулсан нь Монгол Улс шүүхийн



нэгдмэл тогтолцоотой болохыг харуулах бөгөөд дагнасан шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавих бүрэн эрхийг Улсын дээд шүүхэд олгосон байна.

Иймд Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 15 дугаар зүйлийн 15.8, 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан хэлэлцэж өгнө үү” гэжээ.

***Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн хариу тайлбартаа:***

“Монгол Улсад иргэний эрх зүйн харилцаанд оролцогч этгээдүүдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой асуудал, улмаар тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилтыг шүүхийн аргаар буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасны дагуу, түүнчлэн шүүхийн бус аргаар буюу арбитрын ажиллагаагаар хэрэгжүүлж байна.

Үүний эрх зүйн үндэслэл нь Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ.” гэсэн зохицуулалт юм.

Монгол Улсын Арбитрын тухай хууль нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрхийн комисс /ЮНСИТРАЛ/-ын 1985 онд гаргасан Олон улсын арилжааны арбитрын тухай загвар хуультай нийцэж байгаа болно.

Тухайлбал, дээр дурдсан загвар хуулийн 11 дүгээр зүйлд арбитр болон арбитрчдыг томилох журмаа өөрсдөө тохиролцон тогтоож болохоор заасан. Хэрэв ийнхүү тохиролцож чадаагүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрыг шүүх, эсхүл энэ загвар хуулийн 6 дугаар зүйлд заасан бусад байгууллагаас томилж байхаар тогтоожээ. Улмаар энэ загвар хуулийн холбогдох зүйлд шүүх болон холбогдох бусад байгууллагаас гаргасан шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүй байхаар хуульчилсан билээ.

Иймд Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 15 дугаар зүйлийн 15.8, 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн





заалт тус тус Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэхгүй байх дараах үндэслэлтэй гэж үзэж байна.

Нэгдүгээрт, талууд маргаантай асуудлаа хөндлөнгийн этгээдээр шийдвэрлүүлж байгаа явдал нь өөрөө шүүхийн бус арбитрын ажиллагаа мөн бөгөөд олон улсын арилжааны арбитрын ажиллагааны процедурыг нэг мөр болгож байгаа ЮНСИТРАЛ-ын систем болно.

Хоёрдугаарт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 2006 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 61/33 дугаар шийдвэртээ олон улсын худалдаа, олон улсын арилжааны арбитрын эрх зүйн хүрээнд батлагдсан Олон улсын арилжааны арбитрын загвар хууль нь дэлхийн улсууд дотоодын хууль тогтоомжоо боловсронгуй болгох, төгөлдөршүүлэхэд найдвартай үндэс суурь болж байгаа талаар дурдаад ийнхүү загвар хуулийн үзэл санааг үндэснийхээ хууль тогтоомжид тусгахыг зөвлөмж болгов.

Иймд Монгол Улсын Арбитрын тухай хуулийн дээр дурдсан заалтууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрхийн комисс /ЮНСИТРАЛ/-ын 1985 онд гаргасан Олон улсын арилжааны арбитрын тухай загвар хуулийн заалт болон дэлхий нийтийн жишигт бүрнээ нийцэж байна.

Гуравдугаарт, арбитрын ажиллагаанд шүүхээс оролцох оролцоо хязгаарлагдмал бөгөөд зөвхөн хуульд заасан үндэслэл, журмаар оролцож байна. Өөрөөр хэлбэл, арбитрын зарим ажиллагаатай холбогдуулан гаргасан арбитрын шийдвэрийн агуулгыг хянахгүйгээр, тухайлбал, маргааны харьяалал тогтоох, нотлох баримт бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх зэрэг цөөн тооны ажиллагааг нь баталгаажуулах асуудлыг ойлгоно.

Дөрөвдүгээрт, Шүүхийн тухай хуулиар Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэхээр хуульчилсан билээ.

Улмаар хяналтын шатны шүүх болох Улсын дээд шүүх нь зөвхөн давж заалдах шатны шүүхийн иргэн, эрүү, захиргааны хэргийн магадлалтай холбогдуулан гаргасан эрх зүйн маргааныг талуудын гомдол, Улсын ерөнхий прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр хянан шийдвэрлэхээр тогтоосон юм.



Харин хяналтын шатны шүүхээр арбитрын ажиллагаатай холбогдсон давж заалдах шатны шүүхийн шийдвэр хянагдахгүй болно.” гэжээ.

**Гурав.** Мэдээллийн шаардлагатай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитр, Улсын дээд шүүхээс тайлбар, мэдээлэл, баримтыг гаргуулсан болно.

### **ҮНДЭСЛЭЛ:**

1. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч этгээдүүдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргааныг шүүхийн болон шүүхийн бус аргаар шийдвэрлэж болох ба арбитраар маргаан шийдвэрлүүлэх ажиллагаа нь талууд сайн дураараа, хүсэл зоригоо илэрхийлэн харилцан тохиролцож, өөрсдийн сонгосон хөндлөнгийн этгээдээр маргаанаа шийдвэрлүүлдэг шүүхийн бус арга юм.

Арбитрын тухай хуульд зааснаар арбитрч томилох, маргааны харьяалал тогтоох зэрэг асуудлаар аль нэг талын гомдлоор давж заалдах шатны шүүх арбитрын ажиллагаанд оролцож байгаа нь олон улсын нийтлэг жишиг бөгөөд үүнийг шүүхийн журмаар маргааныг шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг гэж үздэггүй.

2. Хуралдааны явцад мэдээлэл гаргагч иргэн С.Номын баясгалан Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Байнгын арбитр энэ хуулийн 15.5-15.7, 17.4, 18.2, 20.6-д шүүх шийдвэрлэхээр заасан маргааныг өөр этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн этгээдийн гаргасан шийдвэр эцсийн байна.”, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 18.1-д заасан асуудлаар үүссэн маргааныг давж заалдах шатны шүүх болон байнгын арбитрын дүрэмд заасан эрх бүхий этгээд шийдвэрлэх ба тухайн шийдвэр эцсийн байна.” гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн мэдээллийн шаардлагаасаа татгалзсан болно.

3. Арбитрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 15.5-15.7-д заасан маргаантай асуудлаар гаргасан давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.”, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт “Талууд энэ хуулийн 20.5-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны



шүүхэд гомдол гаргаж болох ба тухайн шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах, ... эрхтэй. ...”, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2/ дахь заалтад “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэж заасныг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1/ дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Арбитрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 15.5-15.7-д заасан маргаантай асуудлаар гаргасан давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.”, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт “Талууд энэ хуулийн 20.5-д заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болох ба тухайн шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах, ... эрхтэй. ...”, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2/ дахь заалтад “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.



2.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Н.ЖАНЦАН**

**ГИШҮҮД**

**Т.ЛХАГВАА**

**Ш.ЦОГТОО**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Д.СОЛОНГО**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

**Индекс: 14003**